

2019 07 26

254

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн шинэчлэх,
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Зам, тээврийн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. “Зам, тээврийн салбарын 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл хангах нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө”-г 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. Төлөвлөгөөнд туссан арга хэмжээ бүрийг хариуцсан чиглэлээр бүрэн хэрэгжүүлж, байгууллага тус бүрдээ өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг харьяа агентлаг, байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

4. “Зам, тээврийн салбарын 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл хангах нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө”-нд туссан арга хэмжээ нэг бүрийн хэрэгжилт, салбар байгууллагынхаа хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл хангах талаар авсан арга хэмжээ, үр дүн, цаг үеийн нөхцөл байдлын талаар мэдээ, тайланг сар бүрийн 25-ны өдрийн дотор Ажлын хэсэгт ирүүлж байхыг харьяа агентлаг, байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

5. Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Зам, тээврийн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах Ажлын хэсгийн даргад даалгасугай.


6. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын “Ажлын хэсгийн бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай” 2018 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 180 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ЭНХ-АМГАЛАН

Зам, тээврийн хөгжлийн сайдын
2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн
257 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

Зам, тээврийн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах
Ажлын хэсгийн бүрэлдэхүүн



Ажлын хэсгийн дарга

Зам, тээврийн хөгжлийн Дэд сайд

Ажлын хэсгийн орлогч дарга

Зам, тээврийн хяналтын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга

Зам, тээврийн хяналтын хэлстийн
Гүүр, хиймэл байгууламжийн хяналт
хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Авто замын бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга

Автотээврийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга

Төмөр зам, далайн тээврийн бодлогын
хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Иргэний нисэхийн ерөнхий газрын тэргүүн
дэд дарга

“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын
Захирал

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын
Захирал

Монгол-Оросын хувь нийлүүлсэн
“Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн
Замын ерөнхий инженерийн орлогч

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн дэд
захирал

---oOo---

Зам, тээврийн хөгжлийн сайдын
2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн
25/ дугаар тушаалын 2 дугаар хавсралт

**ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН 2019-2020 ОНЫ ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХ
НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа (он, сараар)	Шаардагдах хөрөнгийн эх үүсвэр (сая төгрөг)	Хэрэгжүүлэх байгууллага
1	2	3	4	5
Нэг. Зохион байгуулалтын талаар				
1.	Байгууллагын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөө батлан мөрдөж ажиллах	2019 оны 08 дугаар сарын 10-ны дотор	-	Салбарын бүх байгууллага
2.	Төв болон орон нутгийн салбар байгууллагын тоног төхөөрөмж, барилгын сантехник, дулаан, цахилгааны шугам, сүлжээний засвар, дулаалга, үйлчилгээг хийж, өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүрэн хангах, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах	2019 оны 10 дугаар сарын 1-ний дотор	Байгууллагын төсвөөр	Салбарын бүх байгууллага
3.	Өвөлжилтийн бэлтгэл ажлын явц, үр дүнгийн талаар олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчлах ажлыг зохион байгуулах	Тогтмол	-	Салбарын бүх байгууллага
4.	Албан хаагчдыг өвөлд бэлтгэх, онцгой үед ажиллах, мэдээлэл шуурхай дамжуулах зохион байгуулалт, техникийн бэлэн байдлыг хангах зэрэг чиглэлээр холбогдох албан хаагчдад сургалт зохион байгуулах	2019 оны 09 дүгээр сар	Байгууллагын төсвөөр	Салбарын бүх байгууллага
5.	Он дамжин үргэлжлэх бүх төрлийн барилга байгууламжийг өвлийн зогсолт хийх үеэр осол аваар гарахаас сэргийлсэн арга хэмжээг авах, шаардлагатай тэмдэг байрлуулах, сэргээх, хамгаалалт хийх	2019 оны 10 дугаар сарын 30-ны дотор	Гүйцэтгэгчийн зардлаар	Гүйцэтгэгч компаниуд
6.	Техник хэрэгслийг өвлийн горимд шилжүүлэх, холбогдох үзлэг, шалгалтыг хуваарь гарган гүйцэтгэх	2019 оны 10 дугаар сарын 30-ны дотор	-	ИНЕГ, АТҮТ, ЗТХТ, УБТЗ, МТЗ
7.	Өвөлжилтөд шаардлагатай худалдан авах гэрээг байгуулах, гүйцэтгэлийг бүрэн хангаж дуусгах	2019 оны 10 дугаар сарын 30-ны дотор	-	Салбарын бүх байгууллага
8.	Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явцыг салбарын нэгдсэн ажлын хэсэгт тогтмол тайлагнах	Сар бүрийн 25-ны дотор	-	Харьяа байгууллагууд
Хоёр. Авто зам, автотээврийн чиглэлээр				

1.	Улс, хот хооронд, нийслэлийн зорчигч тээврийн 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах, биелэлтэд хяналт тавьж, сар тутам дүгнэж, холбогдох байгууллагуудад танилцуулж ажиллах	Тайлан-сар бүрийн 25-нд		АТҮТ ТӨҮГ, Нийслэлийн тээврийн газар
2.	Хот хоорондын зорчигч тээвэрлэлт гүйцэтгэж буй аж ахуйн нэгж байгууллагуудын тээврийн хэрэгсэлд шугам замын шалгалт явуулах, Тээвэрлэгч аж ахуй нэгж байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл хангах чиглэл өгөх, тайлан гаргах.	2019-2020	-	АТҮТ ТӨҮГ
3.	Улс, хот хооронд, орон нутгийн нийтийн тээвэрлэлт гүйцэтгэж буй аж ахуйн нэгж байгууллагуудын тээврийн хэрэгслийг хуваарийн дагуу техникийн хяналт үзлэгт хамруулж, техникийн бүрэн бүтэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах	2020 оны 3 дугаар сар 9 дүгээр сар	-	АТҮТ ТӨҮГ,
4.	Улс, хот хооронд зорчигч тээвэрлэлт гүйцэтгэж буй аж ахуй нэгж, байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явцыг газар дээр нь шалгаж техникийн бэлэн байдлыг хангуулах, сааталгүй үйлчлэх нөхцөл бүрдүүлэх	2019 оны 10 дугаар сар	-	АТҮТ ТӨҮГ
5.	Улс, хот хоорондын зорчигч тээврийн хэрэгсэлүүдийн байршил тогтоох төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангуулах	2019 оны 9 дүгээр сар		
6.	Замын нөхцөл байдал хүндэрч, халтиргаа гулгаа үүссэн үед хот хооронд зорчигч тээвэрлэж буй аж ахуйн нэгж байгууллагын тээврийн хэрэгсэлд хурд хэтрүүлсэн тохиолдолд жолооч болон холбогдох албан тушаалтанд шуурхай мэдээлж ажиллах, тухай бүр хариуцлага тооцож ажиллах	Тогтмол	-	АТҮТ ТӨҮГ
7.	АТҮТ ТӨҮГ, салбар нэгжүүд болон хамтран ажиллаж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах “Өвөлд бид бэлэн” өдөрлөг зохион байгуулах	2019 оны 10 дугаар сар	-	АТҮТ ТӨҮГ
8.	Он дамжин хэрэгжих авто зам, гүүр, их засвар, шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэгч комданиудын хариуцсан объектуудын өвлийн улирлын туршид хийгдэх арчлалт тэмдэг, хаалт, гүүр хоолойн буцаан дүүргэлт зэрэг ажлуудыг хийлгэх	2019 оны 10 дугаар сар	Гүйцэтгэгчийн зардлаар	ЗТХЯ ЗТХТ ТӨҮГ
9.	ЗТХТ ТӨҮГ болон Авто замын засвар арчлалт хариуцсан байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах, хуваарьт шалгалт хийх	2019 оны 10 дугаар сар	-	ЗТХЯ, ЗТХТ ТӨҮГ
10.	Өвлийн улиралд хүндрэл үүсдэг зам даваанд цаснаас хамгаалах далан байгуулах	2019 оны 10 дугаар сар		ЗТХЯ, ЗТХТ ТӨҮГ
11.	Цаг агаарын хүндрэлийн үед Улсын чанартай авто зам, даваан дээр ажиллах “Шуурхай ажлын хэсэг”-ийг сайдын тушаалаар батлуулж, шаардлагатай зохион байгуулалтыг хийх	2019.11сар– 2020.04 сар	-	ЗТХЯ, ЗТХТ ТӨҮГ

12.	Шуурхай ажлын хэсгийг гаргаж үйл ажиллагааг тогтмолжуулах. Үйл ажиллагаанд нь тогтмол хяналт тавьж ажиллах, Зам, даваануудад хуурай элс, үнсийг нөөцлүүлэх, байршуулж бэлтгүүлэх ажлыг гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих	2019 оны 11 дүгээр сар	Улсын төсөв 1 201 сая	ЗТХЯ, ЗТХТ ТӨҮГ
13.	Улсын чанартай авто замын онцгой хүндрэлтэй хэсгүүдэд түр зам гаргах, чиглэл заасан тэмдэг тавих	2019 оны 11 дүгээр сар	-	ЗТХТ, АЗЗА ТӨХК-иуд
14.	Төлбөр авах цэгүүдийн өвлийн бэлтгэл хангах, гадна зам талбайн засвар, тохижилт, гэрэлтүүлэг, замын тэмдэг, тэмдэглэгээг сайжруулах	2019 оны 11 дүгээр сар		ЗТХТ ТӨҮГ
Гурав. Төмөр замын тээврийн чиглэлээр				
1.	Зорчигчийн вагоны техникийн бэлэн байдал, засвар, зэхэлтийн аж ахуйг өвөлд бэлтгэх, хэрэгжилтэд хяналт тавих	2019-2020 онд	Урсгал зардлаар	ЗТХЯ, “УБТЗ” ХНН
2.	Ачааны вагон паркийг өвлийн тээвэрт бэлтгэх, өвлийн хувцасны хангалт хийх, хэрэгжилтэд хяналт тавих	2019 оны 9-10 дугаар сард		“УБТЗ” ХНН, МТЗ ТӨХК, ГТХЗНТ УТҮГ
3.	Зүтгүүрийн паркийг өвлийн тээвэрт бэлдэх, өвлийн түлшээр хангах, боловсон хүчний сургалт зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих	2019 оны 8-9 дүгээр сард		“УБТЗ” ХНН, МТЗ ТӨХК, ГТХЗНТ УТҮГ
4.	Өвлийн улиралд ажиллахгүй төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн машин механизмын өвлийн горимд шилжүүлэн хадгалах хамгаалах, хэрэгжилтэд хяналт тавих	2019 оны 11 дүгээр сард		“УБТЗ” ХНН, МТЗ ТӨХК, ГТХЗНТ УТҮГ
5.	2018 онд үерт авсан зам, гүүрийн судалгаа хийх, эрсдэл тогтоож, судалгааны дүн, цаашид авах арга хэмжээг тодорхойлж тайланг ЗТХЯ-д ирүүлэх	2019 оны 11 дүгээр сард		“УБТЗ” ХНН, МТЗ ТӨХК, ГТХЗНТ УТҮГ
6.	Төмөр замын засвар үйлчилгээ, зам засварын техникийн бэлэн байдлыг хангах, боловсон хүчний сургалт хийх, хэрэгжилтэд хяналт тавих	2019 оны 11 дүгээр сард		ЗТХЯ, “УБТЗ” ХНН, МТЗ ТӨХК, ГТХЗНТ УТҮГ
7.	Дохиолол холбоо эрчим хүч, ус хангамжийн зэрэг аж ахуйн нэгжүүдийг өвөлд бэлдэх, хэрэгжилтэд хяналт тавих	2019 оны 11 дүгээр сард		ЗТХЯ, “УБТЗ” ХНН, ГТХЗНТ УТҮГ
8.	Суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч байгууллагуудын өвлийн бэлтгэл ажлыг хангуулах, хэрэгжилтийн явцад хяналт тавих	2019 оны 11 дүгээр сард		“УБТЗ” ХНН, МТЗ ТӨХК, ГТХЗНТ УТҮГ
Дөрөв. Иргэний нисэхийн чиглэлээр				
1.	Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын болон орон нутгийн нисэх буудлуудын цахилгаан, дулаан хангамжийн тасралтгүй ажиллагаа,	2019 оны 9 дүгээр сар		ИНЕГ

	бэлэн байдлыг хангах үзлэг шалгалтыг зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээ авах, хэрэгжилтэд хяналт тавих.			
2.	Төв орон нутгийн нисэх буудлуудын газрын үйлчилгээний автомашинуудыг өвлийн горимд шилжүүлэх засвар үйлчилгээг графикийн дагуу хийж гүйцэтгэх	2019 оны 10 дугаар сар		ИНЕГ
3.	Өвлийн улиралд шаардлагатай хэрэгцээт дизелийн түлш, халаах төхөөрөмжний түлшний нөөцийг бүрдүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих.	2019 оны 10 дугаар сар		ИНЕГ
4.	Төвийн болон орон нутгийн шатахуун түгээх станц, шатахуун хадгалах торх, тоолуур, хэмжүүр, хэмжих хэрэгслийн болон шатахуун цэнэглэгч болон зөөвөрлөгч автомашинуудын засвар үйлчилгээг графикийн дагуу хийж, өвөлжилтийн бэлтгэлийг хангах,	2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор		ИНЕГ
5.	Цаг уурын станц, агаарын навигацийн тоног төхөөрөмж, үйлчилгээний байгууламжуудын ажиллагааны горимыг хавар-зуны ашиглалтаас намар өвлийн ашиглалтад шилжүүлэх техник үйлчилгээ, тохиргооны ажлыг хийх, хэрэгжилтэд хяналт тавих.	2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор		ИНЕГ
Тав. Усан замын тээврийн чиглэлээр				
1.	Хөвөлтийн улиралыг зогсоох шийдвэрийг биелүүлэх зорилгоор усан замын тээврийн хэрэгслүүдийг уснаас гаргах, Усан замын тээврийн хяналтын зориулалтай катер болон завинуудыг өвлийн зогсоолд байршуулаж, техник ашиглалтын зохих шаардлагын дагуу өвлийн зогсоолд байршуулах ажлыг зохион байгуулах, иргэд аж ахуй нэгжүүдэд энэ талаар чиглэл өгч ажиллах, мөн түүнчлэн хяналтын завинуудын 0 зогсолт хийхтэй холбоотой засвар, үйлчилгээний ажлыг хийх.	2019 оны 10 дугаар сар		Далайн захиргаа
2.	Мөсөн замаар тээвэр хийх хуваарь батлуулах, хяналт тавьж ажиллах	2020 оны 1-4 сар		Далайн захиргаа
3.	Хяналтын байрны цахилгаан, дулаан, сантехникийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг ханган харуул хамгаалалт хариуцсан ажилтанд хүлээлгэн өгөх.	2019 оны 10 дугаар сар		Далайн захиргаа